

Эм эмнэлгийн хэрэгслийн тээвэрлэлт

Тус газар нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор ханган нийлүүлэх байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүхий эд бүхий ачааны мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн татан авахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.


БНХАУ-аас орж ирэх ачааны мэдээллийг эрэмбэлэн Улсын онцгой комисс, Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Улаанбаатар төмөр зам ХНН-т тухай бүр хүргүүлж татан авсан. 2022 оны 1-10 сарын байдлаар давхардсан тоогоор 114 ханган нийлүүлэх байгууллагын 521 чингэлэг ачааны мэдээллийг хүргүүлсэн байна. Үүнд:

- Төмөр замаар татан авах шаардлагатай 431 чингэлэг
- Автозамаар татан авах шаардлагатай 19 чингэлэг

Дотоодод саатсан 71 чингэлэг

Эмийн үнэ бүрдэл

Монгол улсад импортоор орж ирдэг эмүүдийн хувьд гааль, НӨАТ, тээвэр, даатгал, ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны зардал, эмийн сангийн үйл ажиллагааны зардал, урсгал зардал зэргээс хамааран эцсийн хэрэглэгчид очихдоо тодорхой хувиар нэмэгдэж борлуулагддаг.



Эмийн үнэ өсөлт /2022 оны байдлаар/

Тээврийн зардлын нэмэгдэл, ханшийн зөрүү, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нэмэлт урсгал зардал, үйлдвэрлэгчийн үнийн өсөлт, түүхий эдийн үнийн өсөлт, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлын нэмэгдэл зэрэгтэй холбоотой эмийн үнэ 114 хүртэлх хувиар нэмэгдсэн.

№	Үнэ өсөлтийн шалтгаан	2019-2020 онд нэмэгдсэн хувь	2020-2021 онд нэмэгдсэн хувь
1	Түүхий эдийн үнийн өсөлт	20%	18%
2	Сав, баглаа боодлын үнийн өсөлт	5%	5%
3	Валютын ханш	4%	3%
4	Тээвэрлэлт, хадгалалтын зардал	46%	130%